



НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХЭД

АРДЧИЛСАН НАМ

Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Чингисийн өргөн чөлөө,
Шинэ дэвшилт холбооны байр.

И-мэйл: info@demparty.mn, Вэбсайт: www.demparty.mn

2020.12.28 № 01/257
танай _____-ны № _____-т

Захиргааны актын биелэлтийг
түдгэлзүүлэх тухай хүсэлт гаргах нь

Ардчилсан намын зүгээс Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт холбогдуулан "Сонсох ажиллагаанд оролцуулахгүй байгаа эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, иргэн С.Эрдэнийн гаргасан Ардчилсан намын 1117237845 хяналтын дугаар бүхий тамгыг хүчингүй болгуулах тухай хүсэлт шийдвэрлэх ажиллагаанд Ардчилсан намыг оролцуулж тайлбар, санал гаргах боломж олгохыг даалгах тухай" нэхэмжлэлийг гаргасан.

Мөн, шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлж, "Улсын бүртгэлийн ерөнхий газрын улсын байцаагчийн 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 6030 дугаартай "Тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгох тухай" дүгнэлт болон улсын бүртгэгчийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Тамга, тэмдгийн хяналтын дугаарын улсын бүртгэлийн хуудас"-аар дахин олгосон тамга, тэмдгийн 9020120477 хяналтын дугаарыг тус тус хүчингүй болгуулах"-аар нэхэмжилсэн.

Шүүхэд гаргасан нэхэмжлэлийн нэмэгдүүлсэн шаардлагатай холбогдуулан дараах хүсэлтийг гаргаж байна. Үүнд:

Ардчилсан намын 1117237845 хяналтын дугаар бүхий тамгыг хүчингүй болгосон улсын байцаагчийн 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 6030 дугаартай "Тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгох тухай" дүгнэлт биелэлт болон уг дүгнэлтийг үндэслэн дахин олгосон тамга, тэмдгийн 9020120477 хяналтын дугаарын улсын бүртгэлийг уг захиргааны хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлэх хүртэлх хугацаанд түдгэлзүүлж, нэхэмжлэгчийн эрхийг зөрчигдөхөөс урьдчилан хамгаалж өгнө үү.

Хариуцагч байгууллага нь нэхэмжлэгчийн тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгох шийдвэр гаргах замаар нэхэмжлэгчийн эрх зүйн байдлыг дордуулж, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг ноцтой зөрчиж байгаа бөгөөд хэрэв уг хууль зөрчсөн захиргааны актууд цаашид хэрэгжих аваас нэхэмжлэгч байгууллагад нөхөж баршгүй гарз хохирол учирч болзошгүй нөхцөл байдал үүсээд байна.

Иймд, үүсээд байгаа нөхцөл байдлыг улам дордуулахгүй байх, нэхэмжлэгчид учирч болох эрсдэл, хохирлоос урьдчилан сэргийлэх үүднээс Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 61 дүгээр зүйлийн

61.1 дэх хэсэгт заасны дагуу захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх дараах арга хэмжээ авах хүсэлтэй байна. Үүнд:

1. Ардчилсан намын тамга, тэмдгийн 1117237845 хяналтын дугаарыг хүчингүй болгосон Улсын бүртгэлийн ерөнхий газрын улсын байцаагчийн 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 6030 дугаартай "Тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгох тухай" дүгнэлтийн биелэлтийг түдгэлзүүлэх;
2. Дээрх дүгнэлтийг үндэслэн дахин олгосон тамга, тэмдгийн 9020120477 хяналтын дугаарын улсын бүртгэлийг түдгэлзүүлэх.

Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр, нэхэмжлэгч байгууллага одоо ашиглаж байгаа тамга, тэмдгийн 1117237845 хяналтын дугаар бүхий тамгаа хэвийн ашиглах, шинээр олгоод байгаа маргаан бүхий тамга, тэмдгийн 9020120477 хяналтын дугаарын улсын бүртгэлийг түдгэлзүүлснээр Ардчилсан намын тамга, тэмдэгтэй холбоотой маргаан үүсгэхгүй байх, хүчингүй тамга тэмдэг ашигласантай холбоотой аливаа зөрчил гаргахгүй байх, аливаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд Ардчилсан намын тамгатай холбоотой будилаан, төөрөгдөл үүсгэхгүй байх зэрэг ач холбогдолтой юм.

Иймд, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нөхцөл байхгүй тул хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж өгнө үү.

Хүсэлт гаргасан:

АРДЧИЛСАН НАМЫН ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ТУВААН

